



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 1125

Шивээговь сум

“Өвсний фонд бүрдүүлэх ажлын гүйцэтгэлийг
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд “Өвсний фонд бүрдүүлэх” зорилгоор худалдан авсан өвсийг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

- Комиссын дарга: Д.Мөнхзаяа
(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Гишүүд: С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг дарга)
Б.Баярцэцэг
(Нярав)
М.Эрдэнэбаатар
(Хогны машины ачигч)
- Нарийн бичгийн дарга: Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2.Дээрх ажлын тоо ширхэгт хяналт тавин хүлээж авахыг нярав (Б.Баярцэцэг)-т, ажлыг чанартай зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж, тайлагнан ажиллахыг комиссын дарга (Д.Мөнхзаяа)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ОТГОНЖАРГАЛ

